



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 20 өдөр

Дугаар 1/121

Мөрөн сум

Төсөвт өртгийн дээд хязгаар  
тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.6, 65 дугаар зүйлийн 65.1.4, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн ээлжит ХХIII хуралдааны 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн  
**ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Аймгийн орон нутгийн хөгжлийн сан дахь “Зураг төсвийн сан”-аас санхүүжүүлэх шинээр барих, засварлах, шинэчлэх барилга байгууламжийн ажлын зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаарыг 1 дүгээр, “ажлын гүйцэтгэл”-ийн төсвөөс санхүүжүүлэх зөвлөх үйлчилгээний төлбөрийн төсөвт өртгийн дээд хязгаарыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Төсөл арга хэмжээний зураг, төсвийг боловсруулах зөвлөх үйлчилгээний лүүлэх гүйцэтгэгч сонгож гэрээ байгуулах, хэрэгжилтийг хангах үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг аймгийн Худалдан авах ажиллагааны газар (Б.Должинсорогдог), сумын Засаг дарга, агентлаг байгууллагын удирдлагуудад тус тус үүрэг болгосугай.

3. Төсөл арга хэмжээнүүдийн зураг төсвийн үнийг хавсралтад заагдсан эх үүсвэрээс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Базар), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Оюунтуяа) нарт тус тус даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т даалгасугай.

ОРЛОГЧ

М.ХУЯГБААТАР



6712010357  
Захирамж 2024

Аймгийн Засаг даргын 2024 оны  
 03 дугаар сарын 20-ны өдрийн  
 1/12 дугаар захирамжийн 1 дүгээр  
 хавсралт

**АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН ДАХЬ "ЗУРАГ ТӨСВИЙН САН"-ААС  
 САНХҮҮЖҮҮЛЭХ ШИНЭЭР БАРИХ, ЗАСВАРЛАХ, ШИНЭЧЛЭХ, БАРИЛГА  
 БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
 ТӨЛБӨРИЙН ТӨСӨВТ ӨРТГИЙН ДЭЭД ХЯЗГААР**

№	Арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	тайлбар
1	Хөвсгөл аймгийн Мөрөн сумын ерөнхий боловсролын эрдмийн далай сургуулийн А, Б хичээлийн байрны их засварын ажлын зураг төсөл боловсруулах	20,000,000	Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна.
2	Чандмань-Өндөр сумын Доншиг чиглэлд цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих ажлын зураг боловсруулах	20,000,000	Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна
3	Хөвсгөл аймгийн Ханх сумын цахилгаан хангамжийн 10 кВ-ын ЦДАШ-ын дамжуулагч утсыг бүрээстэй дамжуулагчаар солих, модон тулгуурыг төмөр бетон тулгуураар шинэчлэх ажлын зураг боловсруулах	20,000,000	Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна.
4	Мөрөн сумын спорт заалны барилгын зураг боловсруулах /7-р баг/	20,000,000	Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна.
5	Сумын төвийн нэгдсэн халаалтын уурын зуухны барилга байгууламж, дулаан хангамжийн зураг төсөл боловсруулах /Алаг-Эрдэнэ сумын Хатгал тосгон/	50,000,000	Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна.
	Нийт дүн	130,000,000	

Аймгийн Засаг даргын 2024 оны  
03 дугаар сарын 20-ны өдрийн  
11/21 дугаар захирамжийн 2 дугаар  
хавсралт

УЛС, ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ШИНЭЭР БАРИХ, ЗАСВАРЛАХ,  
ШИНЭЧЛЭХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН “АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ”-ИЙН ТӨСВӨӨС  
САНХҮҮЖҮҮЛЭХ ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
ТӨСӨВТ ӨРТГИЙН ДЭЭД ХЯЗГААР

№	Арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	тайлбар
1	Хилэнтийн гүүрнээс наашаа Мөрөнгийн чиглэлд хатуу хучилттай авто зам тавих ажлын зураг боловсруулах	20,000,000	Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна
	Нийт дүн	20,000,000	